

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**7 сар
2014**

Улаанбаатар хот

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар.....	4
Товч танилцуулга.....	11
Үндсэн үзүүлэлтүүд.....	26
I. Хөдөлмөр	27
II. Өрхийн орлого, зарлага	37
III. Нийгмийн даатгал, халамж.....	34
IV. Эрүүл мэнд	42
V. Байгаль орчин	46
VI. Гэмт хэрэг.....	48
VII. Дотоодын нийт бүтээгдэхүүн	52
VIII. Мөнгө, банк, даатгал	59
IX. Төрийн санхүү	66
X. Гадаад худалдаа	69
XI. Үнэ	79
XII. Хөдөө аж ахуй	98
XIII. Аж үйлдвэр	101
XIV. Дотоод худалдаа	106
XV. Тээвэр	108
XVI. Зочид буудал, зоогийн газар	110
XVII. Даатгал	112
Хавсралт	113

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэгээ:

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГО	Говь-Алтай
ДО	Дорноговь
ДД	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
ДА	Дархан-Уул
УБ	Улаанбаатар
ОР	Орхон
ГС	Говьсүмбэр

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв

(I, II, III, IV, V... г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	мэдээлэл байхгүй
0.0	маш бага тоо
-	гүйцэтгэл байхгүй.

Г “Үүнээс” гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон иргэнийг ажиллагчдад хамруулна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцохдоо зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн хэмжээг ажиллагчдын дундаж тоонд хуваана.

Тайлант хугацаанд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын нийт хэмжээг ажиллагчдын дундаж тоонд хувааж, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг тооцно. Цалин, түүнтэй адилтгах орлогод үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, цалинтай адилтгах бусад орлогыг оруулна.

Өрхийн орлого, зарлага

Үндэсний статистикийн хороо 1966 оноос эхлэн Өрхийн орлого, зарлагын судалгааг явуулж байгаа бөгөөд 2007 оны 7 дугаар сарын 1-нээс Өрхийн орлого, зарлагын судалгаа, Амьжиргааны түвшний түүвэр судалгааг нэгтгэн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г Монгол Улсын нийт өрхийг төлөөлөх улиралд 4050, жилд 16200 өрхийг түүвэрлэн авч, тэдгээр өрхийн гишүүдийн нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн байдал, өрхийн орлого, зарлага, хэрэглээний хэмжээ, сууцны нөхцөлийн талаарх тоо мэдээллийг

цуглуулж байна. Энэхүү судалгааны үр дүнг улс, бүсийн түвшинд, суурьшлаар гаргадаг бөгөөд 2013 оноос эхлэн сондгой тоотой онуудад судалгааг хураангуй хэлбэрээр буюу өрхийн орлого, зарлагын судалгаа явуулж, тэгш тоотой онуудад 2 жил тутамд дэлгэрэнгүй хэлбэрээр аймгийн түвшинд ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцдог болсон.

Өрхийн нийт орлогыг өрхийн мөнгөн орлого дээр өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлсийг тухайн орон нутгийн зах зээлийн дундаж үнээр үнэлсэн мөнгөн дүнг нэмж тодорхойлно.

Өрхийн мөнгөн орлого цалин хөлс; тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор; хувийн аж ахуйн орлого болон бусад орлогоос бүрдэнэ. Хувийн аж ахуйн орлогод мал аж ахуйн болон газар тариалангийн үйлдвэрлэлийн орлого; хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогыг оруулна.

Өрхийн нийт зарлагыг өрхийн мөнгөн зарлага дээр өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлсийг тухайн орон нутгийн зах зээлийн дундаж үнээр үнэлсэн мөнгөн дүнг нэмж тодорхойлно.

Өрхийн мөнгөн зарлагад хүнсний бүтээгдэхүүний; хүнсний бус бараа, үйлчилгээний; бусдад өгсөн бэлэг, тусламж болон бусад зарлага багтана.

Нэг өрхөд ногдох сарын дундаж орлого, зарлагыг улирлын турш уг судалгаанд хамрагдсан өрхийн сарын дунджаар тооцсон.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон

нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл /-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Байгаль орчин

Агаарын бохирдол гэж агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Хүлцэх агууламж гэж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин гэж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно.

Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг;
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг;
- Бусад гэмт хэрэг.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

- Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохироогч буюу харсан хүн шууд заасан;
- Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон;
- Уг этгээд хэргээ илчлэн ирсэн;
- Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тодорхой хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдсэн өртгийн хэмжээ юм.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно.

Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж, нэмэгдсэн өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хуримтлал, цэвэр экспортын нийлбэрээр тодорхойлохыг эцсийн ашиглалтын; хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, үйлдвэрлэл болон импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого зэрэг орлогын элементийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ий улирлын тооцоонд тухайн салбарын жилийн үйл ажиллагааны улирлын өөрчлөлтийг харуулж чадах богино хугацааны шалгуур үзүүлэлтийг ашиглан, тэдгээрийн өсөлт, бууралтын хандлагаар салбарын нэмэгдсэн өртгийг тооцно.

Үйлдвэрлэлийн аргаар буюу салбараар нэмэгдсэн өртгийн хэмжээг тооцохдоо салбарын үндсэн үзүүлэлтийн улирлын гүйцэтгэлийг өмнөх оны улирлын нэмэгдсэн өртөг болон салбарын үндсэн үзүүлэлтийн харьцаагаар үржүүлж тооцно. Дараах томъёог ашиглана.

$$X_{q, \beta+1} = I_{q, \beta+1} * \left(\frac{X_{4, \beta}}{I_{4, \beta}} \right)$$

X – нэмэгдэл өртгийн хэмжээ

I – салбарын үндсэн үзүүлэлтийн хэмжээ

q - улирал

$\beta+1$ – тайлант он

β – тайлант оны өмнөх жил

Мөнгө, банк, даатгал

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Банкнаас гадуурх мөнгийг тооцохдоо

Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс банкуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасна.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлтэд зөвхөн цэвэршүүлсэн алтны харилцах дансны үлдэгдэл хамрагдах бөгөөд бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдлийг хамруулахгүй.

Хадгаламжийн сертификатыг арилжааны банкнаас гаргасан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй хадгаламжийн сертификатаар тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл, бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Нөөц мөнгө /M0/-ийг банкны касст байгаа бэлэн мөнгө, банкнаас гадуурх мөнгө болон Монголбанк дахь банкуудын төгрөг, валютын харилцах, валютын хадгаламжийн нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлогдоно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Гадаад валютын албан нөөцөд Монголбанкны эзэмшилд байгаа, захиран зарцуулахад бэлэн, чөлөөтэй хөрвөдөг гадаад валют хамрагдана.

Үнэт цаас гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компаний бүх төрлийн хувьцаа,

компаний гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг (опцион), хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” Монгол Улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;

Өрийн бичиг (бонд) гэж тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг;

Хувьцаа гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг;

Брокерийн үйл ажиллагаа гэж үнэт цаасны зах зээлд бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг;

Дилерийн үйл ажиллагаа гэж үнэт цаасны зах зээлд ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг;

Хэлцэл гэж үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг;

Бүртгэлтэй компаний тоо гэж Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхтэй хийдэг хувьцаат компаний тоог ойлгоно.

Зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаний нийтэд гаргасан үнэт цаасны тоо, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлно.

ТОП -20 индекс нь үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралтаар үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлно. Индексийг дараахь томъёогоор тооцно.

$$I = \frac{P}{C} * 100$$

I - Тухайн өдрийн индекс

P - Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ

C - Зах зээлийн суурь үнэлгээ

Төрийн санхүү

Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Улсын Их Хурал (УИХ)-аас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв нь улсын төсөв, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Төсвийн орлого нь тогтворжуулалтын сангийн болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Татварын болон татварын бус орлогоос урсгал орлого бүрдэнэ.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна. Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

УИХ-аас 2010 оны 6 сарын 24-ний өдөр батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.5-т нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нь гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн суурь орлогын нийлбэр гэж заасны дагуу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэнцлийг тооцож байна. Гол нэр төрлийн эрдэс баялаг гэж жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг ойлгоно. Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого гэж жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тухайн ямар төрлийн эрдэс баялгаас уг хуулийн 11.1.3-т заасны дагуу тодорхойлсон үнийн түвшинг баримтлан тооцож төсөвт оруулах орлогын дүнг ойлгоно.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн нийт зарлагын зөрүүгээр тодорхойлно.

Гадаад худалдаа

Гаалийн ерөнхий газрын статистикт үндэслэн гадаад худалдааны салбарын үндсэн үзүүлэлтийг тооцож байна. Түүнчлэн Дэлхийн худалдааны байгууллагаас зөвлөмж болгосон “Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг тогтоодог.

Барааны экспорт гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс эргэн оруулах үүрэггүйгээр барааг гадаадад гаргахыг ойлгоно.

Барааны экспортод эх орны үйлдвэрлэлийн барааг гадаадад гаргах, мөн реэкспортыг оруулна. Эх орны үйлдвэрлэлийн бараанд мөн түүнчлэн улс оронд оруулсан, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.

Барааны реэкспортод Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт урьд нь оруулсан боловч ямар нэг дахин боловсруулалт хийгдээгүй, гаалийн татвар, хураамж болон төлбөргүй, эдийн засгийн хориг хязгаарлалтгүйгээр гадаадад гаргасан барааг оруулна.

Барааны импорт гэж эргүүлж гаргах үүрэггүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт гадаадаас бараа оруулахыг ойлгоно.

Импортод улс орны эдийн засгийн хэрэглээнд зориулж гадаадаас оруулсан бараа, мөн реимпортлох барааг хамруулна. Реимпортын бараанд Монгол Улсын нутаг дэвсгэрээс урьд нь гаргасан хэдий ч эргүүлэн оруулсан барааг оруулна.

Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны барааны нийт эргэлтийг тодорхойлно.

Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн дараах томъёог ашиглаж байна.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлант үе,

0 - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ

\sum - нийлбэрийн тэмдэг

Үнэ өсч тэр хэмжээгээр мөнгөний ханш буурахыг инфляци гэдэг. Инфляцийн түвшинг тооцохдоо дараах томъёог ашиглана.

Үүнд:

$$\text{Инфляцийн түвшин} = \frac{I_t - I_o}{I_o} * 100$$

I_t - тайлант үеийн үнийн индекс

I_o - суурь үеийн үнийн индекс

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн

улсын индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Барилгын гол нэрийн зарим материалын зах зээлийн үнийг Улаанбаатар хотын 4 захаас цуглуулж, сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцож байна.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно. Уг индексийг тооцохдоо Ласпейресийн биет хэмжээний индексийн томъёог ашиглана.

Тээвэр

Ачаа эргэлтийг тооцохдоо тээвэрлэсэн ачааг тээсэн зай/км/-аар үржүүлнэ.

Зорчигч эргэлт нь зорчсон зорчигчдын тоо, аялсан зайн үржвэрээр илэрхийлэгдэнэ.

Шилжүүлсэн тн.км гэж тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километр шилжүүлсэн үзүүлэлтийг ойлгоно.

Тээврийн орлого нь ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаанаас орсон орлого юм.

Дотоод худалдаа

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-ыг оруулна

Худалдааны нийт борлуулалтад тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтыг оруулах бөгөөд тайлант хугацаанд худалдааны

салбарын аж ахуйн нэгжүүдийн цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно. Цэвэр борлуулалтыг тооцохдоо электрон худалдааны борлуулалтыг оруулсан нийт борлуулалтаас борлуулалтын буцаалт, хөнгөлөлтийг хасна.

Нийтийн хоол, зочид буудал

Нийтийн хоол, зочид буудлын цэвэр орлогыг нийт орлого, зардлын зөрүүгээр тооцно.

Зочид буудлын нэг өрөөнд ногдох дундаж орлогыг тодорхойлохдоо нийт орлогыг өрөөний тоонд харьцуулна. Нэг зочинд ногдох дундаж орлогыг тооцохдоо нийт орлогыг нийт үйлчлүүлсэн зочдын тоонд хуваана.

Нийт орлогыг тооцохдоо нэг суудалд ногдох дундаж орлогыг нийт суудлын тоонд харьцуулж тооцно.

**Монгол Улсын нийгэм,
эдийн засгийн байдал**
(2014 оны 7 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




1.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2014 оны 7 дугаар сарын эцэст 56.1 мянга болсны 30.3 мянга нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 34.7 мянга нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 4.2 мян.хүн буюу 10.9 хувиар буурч, өмнөх сарынхаас 799 хүн буюу 2.3 хувиар өссөн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 19.0 мянга буюу 54.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 1.6 пунктээр өсчээ. Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2014 оны эхний 7 сарын байдлаар ажилгүй 55.4 мян. иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 15.6 мян.иргэн ажилд зуучлагдан орж, 63.5 мян.иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ.


Зураг 1.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.6 хувийг магистр, доктор, 36.3 хувийг дипломын болон бакалаврын, 6.9 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.0 хувийг техникийн болон мэргэжлийн, 40.7 хувийг бүрэн дунд, 6.7 хувийг суурь, 1.9 хувийг бага боловсролтой, 0.9 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 24.0 мянга буюу 69.1 хувь нь 15-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаанбаатар хот Булган, Хөвсгөл, Говьсүмбэр, Дундговь, Баянхонгор, Ховд, Увс, Орхон, Өмнөговь аймагт улсын дунджаас 0.5-14.2 пунктээр илүү байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 7 дугаар сарын эцэст, хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээ

Хүн амын эдийн засгийн идэвх

Ажиллах хүчний судалгааны 2014 оны 2 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1204.2 мянга байгаагийн 641.4 мянга буюу 53.3 хувь нь эрэгтэй, 562.8 мянга буюу 46.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын 706.4 мянга буюу 58.7 хувь нь хот, суурин газарт, 497.8 мянга буюу 41.3 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) 2014 оны 2 дугаар улиралд улсын хэмжээнд 63.1 хувь, хотод 57.2 хувь, хөдөөд 73.8 хувь байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 12.5 мянга буюу 14.1 хувиар нэмэгдсэн байна. Мөн эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өмнөх оны мөн үеийнхээс 8.0 мянга буюу 1.1 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.1

15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, хүйсээр, улирлаар (Ажиллах хүчний судалгааны дүнгээр)

Үзүүлэлт	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
Эдийн засгийн идэвхтэй хүн ам, мян.хүн	1 224.2	1 160.3	1 204.2
Эрэгтэй	621.7	608.2	641.4
Эмэгтэй	602.5	552.1	562.8
Ажиллагчид Ажилгүй иргэд	1 135.3	1 051.6	1 102.8
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	88.9	108.7	101.4
Улсын дундаж	63.7	61.7	63.1
Эрэгтэй	68.5	67.6	69.2
Эмэгтэй	59.4	56.4	57.3
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, мян.хүн	696.5	719.3	704.5
Эрэгтэй	285.4	292.0	285.8
Эмэгтэй	411.1	427.3	418.7

15, түүнээс дээш насны нийт хүн амын 704.5 мянга буюу 36.9 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байгаагийн 40.6 хувийг эрэгтэйчүүд, 59.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Эдийн засгийн идэвхгүй нийт хүн амын 236.8 мянга буюу 33.6 хувь нь суралцагчид, 209.3 мянга буюу 29.7 хувь нь тэтгэврийнхэн болон өндөр настан, 78.9 мянга буюу 11.2 хувь нь хүүхэд асарсан, 56.6 мянга буюу 8.0 хувь нь гэрийн ажилтай, 54.8 мянга буюу 7.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Судалгааны дүнгээр 2014 оны 2 дугаар улиралд улсын хэмжээнд ажилгүй иргэд 101.4 мянга байгаагийн 58.0 мянга буюу 57.2 хувь нь эрэгтэйчүүд, 43.4 мянга буюу 42.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 8.4 хувь болж, өмнөх улирлаас 1.0 пунктээр буурлаа.

Хүснэгт 1.2

15, түүнээс дээш насны хүн амын ажилгүйдэл, улирлаар (Ажиллах хүчний судалгааны дүнгээр)

Үзүүлэлт	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
Ажилгүй иргэдийн тоо, мян. хүн	88.9	108.7	101.4
Эрэгтэй	43.0	62.2	58.0
Эмэгтэй	45.9	46.5	43.4
Ажилгүйдлийн түвшин, %			
Улсын дундаж	7.3	9.4	8.4
Эрэгтэй	6.9	10.2	9.0
Эмэгтэй	7.6	8.4	7.7
Хот	7.8	10.1	8.9
Хөдөө	6.6	8.3	7.8



1.2 Өрхийн орлого, зарлага

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2014 оны 2 дугаар улирлын судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 924.1 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 82.9 мян.төг буюу 9.9 хувиар нэмэгдлээ.

Хүснэгт 1.3

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар

Орлогын төрөл	2013 IV-VI	2014 IV-VI	2014 IV-VI / 2013 IV-VI %
Орлого - Бүгд	940 504	1013 956	107.8
1. Мөнгөн орлого - Бүгд	841 193	924 138	109.9
Цалин хөлс	419 466	490 084	116.8
Тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор	149 646	141 912	94.8
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	65 960	85 177	129.1
Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	117 146	117 439	100.3
Бусад орлого	88 975	89 526	100.6
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн"	34 484	36 664	106.3
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн"	64 827	53 154	82.0

Үүнд, цалин хөлсний орлого 70.6 мян.төг буюу 16.8 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 19.2 мян.төг буюу 29.1 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

Нэг өрхийн сарын дундаж бодит мөнгөн орлогын хэмжээ (үнийн нөлөөллийг арилган

тооцсон) 2014 оны 2 дугаар улиралд 806.4 мян. төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 34.8 мян. төг буюу 4.1 хувиар буурчээ.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2014 оны 2 дугаар улиралд 920.3 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 148.1 мян.төг буюу 19.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1.4

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар

Зарлагын төрөл	2013 IV-VI	2014 IV-VI	2014 IV-VI / 2013 IV-VI %
Зарлага - Бүгд	871 547	1010 138	115.9
1. Мөнгөн зарлага - Бүгд	772 236	920 320	119.2
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	208 012	217 594	104.6
Үүнээс:			
Мах, махан бүтээгдэхүүн	79 189	76 653	96.8
Гурил, гурилан бүтээгдэхүүн	48 216	54 073	112.1
Хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага"	544 248	681 135	125.2
Үүнээс:			
Тээвэр	72 064	74 548	103.4
Холбоо	32 479	35 600	109.6
Бусдад өгсөн бэлэг, тусламж	19 976	21 591	108.1
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	34 484	36 664	106.3
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	64 827	53 154	82.0

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага нэмэгдэхэд хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага 136.9 мян.төг буюу 25.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Нэг өрхийн сарын дундаж бодит мөнгөн зарлагын хэмжээ (үнийн нөлөөллийг арилган тооцсон) 2014 оны 2 дугаар улиралд 803.1 мян. төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 30.8 мян. төг буюу 4.0 хувиар өссөн байна.

Хүн амын амьжиргааны байдал

Нэг хүнд ногдох сарын дундаж бодит мөнгөн орлогын хэмжээ (үнийн нөлөөллийг арилган тооцсон) амьжиргааны доод түвшнээс Төвийн бүсэд 73.6 хувь, Зүүн бүсэд 53.9 хувь, Хангайн бүсэд 51.7 хувь, Баруун бүсэд 43.1 хувь, Улаанбаатар хотод 88.0 хувь, улсын дунджаар 68.9 хувиар их байна.

Хүснэгт 1.5

НЭГ ХҮНД НОГДОХ САРЫН ДУНДАЖ БОДИТ МӨНГӨН ОРЛОГО, амьжиргааны доод түвшинтэй харьцуулснаар, бүсээр

	Хүн амын амьжиргааны доод түвшин (2014 оны 4 дүгээр сарын 11-нээс мөрдсөн), төг	Нэг хүнд ногдох сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит мөнгөн орлого, 2014 оны 2 дугаар улирлын байдлаар, төг	Бодит мөнгөн орлого / Амьжиргааны доод түвшин %
Улсын дундаж	157 993	266 774	168.9
Баруун	146 600	209 766	143.1
Хангай	149 600	226 981	151.7
Төв	149 700	259 808	173.6
Зүүн	144 500	222 395	153.9
Улаанбаатар	169 000	317 687	188.0

Хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент 2014 оны 2 дугаар улиралд улсын дунджаар 0.340 байгаа бөгөөд энэ үзүүлэлт Баруун бүсэд 0.304, Хангайн бүсэд 0.330 байгаа нь улсын дунджаас 0.01-0.036 нэгжээр бага, Төвийн бүсэд 0.349, Улаанбаатар хотод 0.342 байгаа нь 0.002-0.009 нэгжээр их байна. Зүүн бүсийн хувьд жини коэффициент улсын дундажтай ижил байна.



I.3. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2014 оны эхний 7 сард 751.1 тэрбум төг, зарлага 734.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 30.9 тэрбум төг буюу 4.3 хувь, зарлага 122.3 тэрбум төг буюу 20.0 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2014 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеийнхээс 30.9 тэрбум төгрөгөөр өсөхөд ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2.7 тэрбум төг буюу 15.4 хувиар буурсан хэдий ч эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 12.5 тэрбум төг буюу 11.4 хувь, тэтгэврийн даатгалын сангийн орлого 9.6 тэрбум төг буюу 1.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2014 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеийнхээс 122.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 9.8 тэрбум төг буюу 9.1 хувиар буурсан хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн зарлага 88.5 тэрбум төг буюу 18.5 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 24.9 тэрбум төг буюу 34.2 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2014 оны эхний 7 сард 191.1 мян.хүнд 80.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 11.4 мян.хүн буюу 6.3 хувиар, олгосон тэтгэврийн хэмжээ 6.1 тэрбум төг буюу 8.2 хувиар өсчээ. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2014 оны эхний 7 сард 60.1 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 1.8 мян.хүн буюу 2.9 хувиар буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 5.7 тэрбум төг буюу 13.9 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 316.6 мян.хүн хамрагдсаны 69.5 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 20.2 хувь нь ахмад настан, 4.7 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, 4.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 1.0 хувь нь алдар цолтой ахмад настай иргэд байна.

Хүний хөгжил” сангаас 2014 оны эхний 7 сард 18 хүртэлх насны 978.9 мянган хүүхдэд 138.0 тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгөнд олгожээ.

Хүснэгт I.6

ТЭГШ БУС БАЙДЛЫН ХЭМЖИГДЭХҮҮН, жил бүрийн 2 дугаар улирлын байдлаар, бүсээр

	Жини коэффициент		Тейлийн индекс	
	2013 IV-VI	2014 IV-VI	2013 IV-VI	2014 IV-VI
Улсын дундаж	0.341	0.340	0.216	0.204
Баруун	0.305	0.304	0.169	0.175
Хангай	0.300	0.330	0.156	0.212
Төв	0.371	0.349	0.307	0.210
Зүүн	0.330	0.340	0.199	0.198
Улаанбаатар	0.347	0.342	0.207	0.201

Орлогын ялгаатай бүлгүүдийн хувьд тэгш бус байдлыг илэрхийлэх тухайн бүлэг доторх болон бүлэг хоорондох тэгш бус байдлыг харуулах Тейлийн индекс 2014 оны 2 дугаар улиралд 0.204 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.012 нэгжээр бага байна.

Улсын хэмжээнд 2014 оны 2 дугаар улиралд хамгийн бага хэрэглээтэй бүлэг нийт хэрэглээнд 7.5 хувийг эзэлж байхад хамгийн чинээлэг хэсгийнх 41.3 хувь байна. Энэ нь хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээний дундаж хэмжээ хамгийн ядуу 20 хувийнхнаас 5.5 дахин их байгааг харуулж байна.

Хүснэгт I.7

Нийт хэрэглээнд хүн амын тооны тэнцүү 5 бүлгийн хэрэглээний эзлэх хувь, бүсээр, 2014 оны 2 дугаар улирлын байдлаар

	Нийт хэрэглээ	5 бүлэг				
		I (Хамгийн ядуу)	II	III	IV	V (Чинээлэг)
Улсын дундаж	100.0	7.5	12.2	16.5	22.5	41.3
Баруун	100.0	8.8	13.0	16.9	21.8	39.5
Хангай	100.0	7.8	12.6	16.7	21.4	41.5
Төв	100.0	6.9	11.7	16.4	23.2	41.8
Зүүн	100.0	7.3	11.9	16.5	22.7	41.6
Улаанбаатар	100.0	7.3	11.9	16.3	22.9	41.6




1.4. Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2014 оны эхний 7 сард 47279 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 47587 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 1464 буюу 3.2 хувиар, хүүхдийн тоо 1544 буюу 3.4 хувиар өссөн байна. Энэ оны 7 дугаар сард 7170 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 64 хүүхэд буюу 0.9 хувиар өссөн байна.



Улсын хэмжээгээр 2014 оны эхний 7 сард нялхсын эндэгдэл 728 болж, өмнөх оны мөн үеийнхээс 66 хүүхэд буюу 10.0 хувиар, 5 хүртэлх насандаа 884 хүүхэд эндэж, 72 хүүхэд буюу 8.9 хувиар нэмэгдсэн байна.




Нялхсын эндэгдэл энэ оны 7 дугаар сард 96 болж, өмнөх оны мөн үеийнхээс 11 хүүхдээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 124 болж, өмнөх оны мөн үеийнхээс 22 хүүхдээр нэмэгджээ.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2014 оны эхний 7 сард 15, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19 болж, өмнөх оны мөн үеийнхээс тус бүр 1-ээр нэмэгдсэн байна.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2014 оны 7 дугаар сард 13 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1-ээр нэмэгдэж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3-аар нэмэгджээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2014 оны эхний 7 сард 19339 болж, өмнөх оны мөн үеийнхээс 5191 буюу 21.2 хувиар буурахад

тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 264 буюу 7.4 хувь, цусан суулгаар өвчлөгчдийн тоо 61 буюу 6,7 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 105 буюу 4.0 хувиар өссөн хэдий ч гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 4588 буюу 92.6 хувь, вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 1068 буюу 60.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



Улаанбаатар хотод 2014 оны 7 дугаар сард ХДХВ/ДОХ-ын тохиолдол 1 гарч, улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 173 болжээ.



1.5. Цаг уур, агаарын бохирдол


Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр 2014 оны 7 дугаар сард Дорнод аймгийн Баян-Уул суманд хамгийн их хур тунадас орж 161.7 мм-т хүрсэн байна. Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн их температур 41.4 хэм, Баянхонгор аймгийн Баянбулаг суманд хамгийн бага температур -4.4 хэмд хүрлээ. Салхины хамгийн их хурд Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 32 м/с хүрсэн байна.

Аймгийн төв, нийслэлд агаарын дундаж хэм 2014 оны 7 дугаар сард олон жилийн дунджаас 0.4 хэм, өмнөх оны мөн үеийнхээс 0.7 хэмээр дулаан байлаа.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2014 оны 7 дугаар сард Улаанбаатар хотын Баруун дөрвөн замын орчимд 24 удаа, 13-р хороолол орчимд 5 удаа, 32-ын тойрог орчимд 4 удаа, 1-р хороолол орчимд 2 удаа; 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн зам орчимд 17 удаа, Хархорин захын орчимд 9 удаа, 32-ын тойрог орчимд 8 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.


Зураг 1.6

Улаанбаатар хотын 32-ын тойрог орчмын агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж, сараар, (мг/м3)



Зураг 1.7

Улаанбаатар хотын Баруун дөрвөн замын орчмын агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж, сараар, (мг/м3)



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2014 оны эхний 7 сарын байдлаар 2787 удаа гарч 136 хүн амь насаа алдаж, 13390 мал, амьтан хорогдсоноос шүлхий өвчнөөр 3454 мал хорогджээ. Энэ оны эхний 7 сард объектын түймэр 2441 удаа, ой хээрийн түймэр 107 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 106 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 29 удаа, 3.5-аас дээш магнитудын газар хөдлөлт 24 удаа, аадар бороо, үерийн аюулт үзэгдэл 23 удаа, малын халдварт боом өвчин 13 удаа, химийн хорт бодистой холбогдох ослын дуудлага 12 удаа бүртгэгджээ.

Объектын түймрийн улмаас 7.4 тэрбум төг, гахайн үржил, амьсгалын замын хам шинж өвчний улмаас 1.5 тэрбум төг, ой хээрийн түймрийн улмаас 1.4 тэрбум төг, аадар бороо, үерийн аюулт үзэгдлийн улмаас 755.4 сая төг, хүчтэй салхи шуурганы улмаас 135.0 сая төг, мал, амьтны халдварт галзуу өвчний улмаас 67.9 сая төгрөгийн хохирол учирч, аюулт үзэгдэл, осолд нийт 448.2 сая төгрөг зарцуулсан байна.

Объектын түймрээр 41 хүн, гол нуурын усанд хүн унасан ослын улмаас 89 хүн, бичил уурхайн нурангины ослын улмаас 3 хүн, ой хээрийн түймрийн улмаас 2 хүн, хүчтэй салхи, шуурганы ослын улмаас 1 хүн амь насаа алджээ.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 109-өөр буурав.

Хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтдын тоо 2014 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеийнхээс 221.5 мян.толгойгоор бага байна.

Хүснэгт 1.8

Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний 4 сарын байдлаар*

Үзүүлэлт	2012 I-VII	2013 I-VII	2014 I-VII	2014 I-VII, 2013 I-VII%
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	2 573	2 896	2 787	96.2
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	143	117	136	116.2
Шатсан гэр, орон сууцны тоо	1 346	1 210	1 287	106.4
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан	7 857	234 880	13 390	5.7
Объектын түймрийн тоо	2 235	2 484	2 441	98.3
Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг	14.3	10.9	11.3	103.6

*-Онцгой байдлын ерөнхий газрын мэдээ




1.6 Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2014 оны эхний 7 сард 15628 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 812 хэрэг буюу 5.5 хувиар өсчээ.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (445), бусдын бие махбодид гэмтэл учруулах (474) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Сэжигтэн нь тодорхойгүй байсан 7067 хэргийн 4075 буюу 52.0 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 5.7 пункт, нийслэлийн хэмжээнд 3.9 пунктээр нэмэгдсэн байна.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2014 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеийнхээс 1.4 хувь, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 5.4 хувь, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 6.2 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 12.3 хувиар нэмэгдсэн байна.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо улсын дунджаар 2014 оны эхний 7 сард 81 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 2.5 хувиар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 5993 хүн гэмтэж, 623 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 795 буюу 15.3 хувь, нас барсан хүний тоо 9 буюу 1.5 хувиар нэмэгдсэн байна.

Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2014 оны эхний 7 сард 43.7 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 18.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 5.4 тэрбум төг буюу 11.0 хувиар буурч, харин нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 2.5 тэрбум төг буюу 15.6 хувиар өссөн байна.

Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, тэрбум төг



Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 2014 оны эхний 7 сард 15163 болж, 951 буюу 6.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 5959 буюу 39.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Улсын хэмжээнд 2014 оны эхний 7 сард 73.1 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 10.1 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 3134 буюу 4.5 хувь, баривчлагдсан хүний тоо 898 буюу 9.7 хувиар нэмэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 413 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 213 хэрэг буюу 2.2 дахин нэмэгдсэн байна.

Малын хулгайн 806 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 5.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 57 хэрэг буюу 7.6 хувиар нэмэгджээ.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2014 оны эхний хагас жилд 6634.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 5.3 хувиар өслөө.

Зураг II.1



Үүнд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 16.3 хувь, аж үйлдвэр, барилгын салбарынх 10.1 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

ДНБ, оны үнээр 2014 оны эхний хагас жилд 9856.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 14.6 хувиар өслөө.


ДНБ, эцсийн ашиглалтын аргаар

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2014 оны эхний хагас жилд 9429.7 тэрбум төг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 6730.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс оны үнээр 941.4 тэрбум төг буюу 11.1 хувь, зэрэгцүүлэх үнээр 327.2 тэрбум төгрөг буюу 5.1 хувиар өслөө.

ДНБ-д оны үнээр эцсийн хэрэглээ 80.5 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 30.1 хувь, цэвэр экспорт -10.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс эцсийн хэрэглээ 6.6 пункт, цэвэр экспорт 10.7 пунктээр өсч, харин хөрөнгийн нийт хуримтлал 17.2 пунктээр буурсан байна.

Зураг II.2

ДНБ-ий бүтэц, хувиар
(эцсийн ашиглалтын аргаар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, оны үнээр)



* Урьдчилсан гүйцэтгэл



II.2 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2014 оны 7 дугаар сарын эцэст 10081.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 26.0 тэрбум төг буюу 0.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 их наяд төг буюу 24.6 хувиар өсөхөд байгууллагын төгрөгийн хадгаламж 1.3 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт II.1

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2013 VII	2014 VI	2014 VII
Мөнгөний нийлүүлэлт M2	8 088.7	10 107.0	10 081.0
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	16.3	26.3	24.6
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.1	- 1.3	- 0.3
Нийт хадгаламж	5 241.3	7 139.8	7 113.0
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	18.6	41.6	35.7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	4.0	0.0	- 0.4
Төгрөгийн хадгаламж	4 013.7	5 692.5	5 550.8
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	28.2	44.5	38.3
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.9	- 0.7	- 2.5
Валютын хадгаламж	1 227.6	1 447.3	1 562.2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 4.6	31.5	27.3
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	11.5	3.0	7.9

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2014 оны 7 дугаар сарын эцэст 859.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.5 тэрбум төг буюу 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 27.4 тэрбум төг буюу 3.3 хувиар өсчээ.

Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2014 оны 7 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 23.4 тэрбум төг буюу 1.2 хувиар өсч, 2048.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2014 оны 7 дугаар сарын эцэст 12225.4 тэрбум төг


болж, өмнөх сарынхаас 76.6 тэрбум төг буюу 0.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 3107.7 тэрбум төг буюу 34.1 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2014 оны 7 дугаар сарын эцэст 550.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 111.9 тэрбум төг буюу 25.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 388.8 тэрбум төг буюу 3.4 дахин өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.5 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2014 оны 7 дугаар сарын эцэст 599.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 32.7 тэрбум төг буюу 5.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 146.8 тэрбум төг буюу 32.4 хувиар өссөн байна.

Зураг II.4

Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг



Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.1 пунктээр буурчээ.

Үнэт цаасны арилжаагаар 2014 оны эхний 7 сард 134.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 32.9 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 19.6 тэрбум төг буюу 17.0 хувь, арилжигдсан үнэт цаас 9.5 сая ш буюу 40.6 хувиар өссөн байна. Харин 2014 оны 7 дугаар сард 0.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 2.7 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Засгийн газрын үнэт цаасны арилжаагаар 2014 оны эхний 7 сард 121.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.


Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2014 оны 7 дугаар сард 16143.8 болж, өмнөх сарынхаас 887.3 нэгжээр өсчээ.

Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2014 оны 7 дугаар сард 1602.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 30.1 тэрбум төг буюу 1.9 хувиар өсчээ.

Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2014 оны 7 дугаар сард 1844.1 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 370.0 төг буюу 25.1 хувиар суларсан

Зураг II.5

ТОП-20 индекс, сарын дундаж, нэгжээр



байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2014 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.6 хувь, 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 1.1 хувиар суларч, 1844.1 төгрөгт хүрчээ.

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2014 оны 7 дугаар сард 297.6 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 57.3 төг буюу 23.8 хувиар суларчээ.

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2014 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувь, 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 1.6 хувиар суларсан байна.

Хүснэгт II.2

Валютын ханш

Монголбанкны төгрөгийн валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

Үзүүлэлт	2013 VII	2014 VI	2014 VII
Ам. доллар	1 474.1	1 824.6	1 844.1
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	9.7	26.9	25.1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	2.5	0.6	1.1
Евро	1 929.4	2 480.9	2 496.3
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	16.6	30.7	29.4
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.6	-0.5	0.6
Юань	240.3	292.8	297.6
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	13.9	24.9	23.8
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	2.5	0.8	1.6
Рубль	45.0	53.0	53.0
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	8.7	19.2	17.8
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.1	2.0	0.0




II.3 Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2014 оны эхний 7 сард 3305.2 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3466.1 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 160.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 0.1 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Зураг II.6

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, тэрбум төг



Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 184.3 тэрбум төг буюу 7.0 хувиар нэмэгдэхэд орлогын албан татварын орлого 10.3 тэрбум төг буюу 1.7 хувь, үүнээс аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 25.9 тэрбум төг буюу 7.3 хувиар буурсан хэдий ч бусад татварын орлого 72.9 тэрбум төг буюу 21.9 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 59.8 тэрбум төг буюу 12.8 хувь, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 37.3 тэрбум төг буюу 3.6 хувь, гадаад худалдааны татварын орлого 19.5 тэрбум төг буюу 10.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 84.7 хувийг татварын орлого, 14.6 хувийг татварын бус орлого, 0.7 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс татварын бус орлогын эзлэх хувь 1.4 пунктээр өсч, татварын орлогынх 1.0 пункт, тогтворжуулалтын сангийн орлогынх 0.4 пунктээр буурчээ (Хавсралт 5).

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2014 оны эхний 7 сард 3466.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 280.4 тэрбум төг буюу 8.8 хувиар өссөн нь эргэж төлөгдөх цэвэр зээл 61.3 тэрбум төг буюу 89.0 хувь, хөрөнгийн зардал 48.8 тэрбум төг буюу 8.3 хувиар буурсан хэдий ч бараа, үйлчилгээний зардал 140.3 тэрбум төг буюу 10.9 хувь, татаас, шилжүүлгийн зардал 139.1 тэрбум төг буюу 12.5 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 111.2 тэрбум төг буюу 89.9 хувиар өссөнөөс шалтгаалжээ.


Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 84.3 хувь, хөрөнгийн зардал 15.5 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 0.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн зардлын эзлэх хувь 2.9 пункт, эргэж төлөгдөх цэвэр зээлийнх 1.9 пунктээр буурч, урсгал зардлынх 4.8 пунктээр өсчээ (Хавсралт 5).



II.4 Гадаад худалдаа

Монгол Улс 2014 оны эхний 7 сарын байдлаар дэлхийн 122 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6088.6 сая ам.долл, үүнээс экспорт 2940.5 сая ам.долл, импорт 3148.1 сая ам.доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 49.9 сая ам.долл буюу 0.8 хувь, экспортын хэмжээ 586.8 сая ам.долл буюу 24.9 хувиар өсч, харин импортын хэмжээ 536.9 сая ам.долл буюу 14.6 хувиар буурчээ.

Зураг II.7



Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхний 7 сард 1.3 тэрбум ам.долларын алдагдалтай гарч байсан бол 2014 оны эхний 7 сард 207.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 1.1 тэрбум ам.долл буюу 84.4 хувиар буурчээ.

Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 586.8 сая ам.долл буюу 24.9 хувиар нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүний экспорт 586.9 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 536.9 сая ам.долл буюу 14.6 хувиар буурахад импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 324.2 сая ам.долл, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 211.6 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.

Хүснэгт II.3

Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, мян.т

	2012 I-VII	2013 I-VII	2014 I-VII
Нүүрс	11 203.8	8 260.3	10 392.3
Зэсийн баяжмал	330.1	332.2	703.9
Төмрийн хүдэр	3 651.8	3 581.9	3 072.1
Боловсруулаагүй газрын тос, мян.барр	1 802.5	2 595.3	3 780.5
Цайрын хүдэр, баяжмал	66.7	80.0	53.2
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт,т	1.2	4.7	3.2




II.5 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувь, оны эхнээс 7.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 14.9 хувиар өслөө.

Зураг II.8

Хэрэглээний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Ерөнхий индекс 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт II.4

Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгээр

	Жин	хувь		
		2014 VII 2013 VII	2014 VII 2013 XII	2014 VII 2014 VI
Ерөнхий индекс	100.0	114.9	107.2	100.4
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	113.1	112.1	99.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	117.0	105.7	100.8
Хувцас, бөс бараа, гутал	16.1	120.8	106.9	100.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	113.3	101.7	102.5
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	119.1	106.4	101.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	113.4	106.5	100.9
Тээвэр	12.2	109.8	107.3	102.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.9	100.0	99.9
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	103.0	102.1	100.1
Боловсролын үйлчилгээ	4.7	127.2	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	116.4	107.2	100.5
Бусад бараа, үйлчилгээ	4.1	123.7	108.7	100.9


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 2014 оны 7 дугаар сарын 0.4 хувийн өсөлтийн 0.3 нэгж (63.0 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

2014 оны эхнээс 7.2 хувиар өссөн өсөлтийн 3.6 нэгж (49.4 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс, 1.1 нэгж (15.5 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас Дархан-Уул, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Хэнтий, Өмнөговь аймагт 0.1-1.5 хувиар буурч, бусад аймагт 0.1-1.4 хувиар өсчээ. Завхан (1.4%) аймаг хамгийн их өсөлттэй байна.

Зураг II.9

Хэрэглээний үнийн индекс, хувь, аймгаар, 2014 оны 7 дугаар сард (өмнөх сар = 100%)




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 0.6 хувь, оны эхнээс 6.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.4 хувиар өслөө

Улаанбаатар хотод хэрэглээний үнэ 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 0.6 хувь өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь, тээврийн бүлгийнх 3.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 31.6 хувийнх нь үнэ өсч, 14.3 хувийнх нь буурч, 54.1 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 49.5 хувь буюу 46 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг II.10

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, САРЫН ӨӨРЧЛӨЛТ



Улаанбаатар хотод худалдаалагдсан барилгын гол нэрийн материалын дундаж үнэ

Улаанбаатар хотод 2014 оны 7 дугаар сард худалдаалагдсан эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 23 нэр төрлийн материалын үнийг мэдээнд хамрууллаа.

Дотоодод үйлдвэрлэсэн вакуум цонхны 1м²-ын дундаж үнэ 2014 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 23.0 мян.төг буюу 25.6 хувиар өсч, 1000 ш улаан тоосгоны үнэ 26.7 мян.төг буюу 9.8 хувь, нэг м³ хөнгөн бетоных 12.1 мян.төг буюу 8.1 хувь, палкных 1.0 мян.төг буюу 3.6 хувиар буурчээ. БНХАУ-д үйлдвэрлэсэн нэг ширхэг шалны хавтангийн үнэ 700 төг буюу 77.8 хувь, 50 кг цементнийх 3.2 мян.төг буюу 50.0 хувь, шаазан суултуурынх 34.0 мян.төг буюу 30.6 хувь, шаазан угаагуурынх 21.8 мян.төг буюу 25.9 хувь, тосон будгийнх 500 төг буюу 20.0 хувь, крантных 10.0 мян.төг буюу 14.3 хувь, уян шүршүүрийнх 5.0 мян.төг буюу 13.3 хувь, нэг боодол чулуугүй хар цаасных 1.0 мян.төг буюу 12.5 хувь, төмөр хаалганых 13.0 мян.төг буюу 7.6 хувь, гадна эмульсийнх 1.0 мян.төг буюу 7.1 хувь, дүүжин таазных 300 төг буюу 5.5 хувь, нэг м² шахмал шалных 500 төг буюу 3.6 хувиар өсч, дотор эмульсний үнэ 2.0 мян.төг буюу 20.0 хувь, нэг кг хадаас 150 төг буюу 5.4 хувиар буурчээ.

БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 2.3 мян.төг буюу 41.8 хувь, ОХУ-д үйлдвэрлэсэн нэг боодол чулуутай хар цаасны үнэ 2.5 мян.төг буюу 11.5 хувиар өссөн байна.

БНХАУ-д үйлдвэрлэсэн 50 кг цементний үнэ 2014 оны 7 дугаар сард өмнөх сарынхаас 1.7 мян.төг буюу 21.9 хувь, шаазан угаагуурынх 6.2 мян.төг буюу 6.3 хувь, шаазан суултуурынх 8.0 мян.төг буюу 5.8 хувиар өсч, гадна эмульсийнх 1.0 мян.төг буюу 6.2 хувь, төмөр хаалганых 5.0 мян.төг буюу 2.7 хувиар буурчээ. ОХУ-д үйлдвэрлэсэн нэг боодол чулуутай хар цаасны үнэ 750 төг буюу 3.1 хувиар өссөн байна.

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2014 оны 7 дугаар сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Увс, Дорноговь, Ховд, Дундговь аймагт хамгийн бага буюу 18.0-28.0 мян.төг; Орхон, Сэлэнгэ, Төв аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 50.0-52.0 мян.төг; адууны ширнийх Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Увс, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь аймагт хамгийн бага буюу 15.0-20.0 мян.төг;

Улаанбаатар хот, Өвөрхангай, Говьсүмбэр, Баян-Өлгий, Төв аймагт хамгийн их буюу 23.0-28.0 мян.төг; ямааны 1 кг цагаан ноолуурын үнэ Булган, Дорноговь, Сүхбаатар, Архангай, Орхон, Дундговь аймагт хамгийн бага буюу 50.0-60.0 мян.төг; Говь-Алтай, Завхан, Ховд, Өвөрхангай, Увс, Баянхонгор аймагт хамгийн их буюу 68.0-70.0 мян.төг байна.




II.6 Хөдөө аж ахуй

2014 оны 8 дугаар сарын 1-ний байдлаар морин хадуурын 84.4 хувь, морин тармуурын 92.8 хувь, тракторын тармуурын 91.0 хувь, тракторын хадуурын 92.8 хувь, дугуйт тракторын 93.7 хувь, хаман боогчийн 81.7 хувь нь хадланд ажиллахад бэлэн болжээ. Морин тармуур, дугуйт трактор, тракторын хадуурын бэлэн байдлын хувь өмнөх оны мөн үеийнхээс 1.0-3.8 пунктээр өсч, хаман боогч, тракторын хамуур, морин хадуурын бэлэн байдлын хувь 0.5-7.1 пунктээр буурсан байна.

Зурга II.11

Хадланд ажиллах техникийн бэлэн байдлын хувь, жил бүрийн 8 сарын 1-ний байдлаар



* Эх үүсвэр: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны мэдээ



II.7 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр, 2014 оны эхний 7 сард 4812.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1335.6 тэрбум төг буюу 38.4 хувиар, үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 1015.5 тэрбум төг буюу 45.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 258.3 тэрбум төг буюу 27.1 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 61.8 тэрбум төг буюу 21.2 хувиар өслөө.

Хүснэгт II.5

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, оны үнээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар тэрбум төг

Аж үйлдвэрийн салбар	2013		2014		2014 I-VII / 2013 I-VII %
	VII	I-VII	VII	I-VII	
Нийт дүн	598.4	3 476.7	780.9	4 812.3	138.4
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	418.9	2 231.7	566.0	3 247.2	145.5
Боловсруулах аж үйлдвэр	151.2	954.1	177.5	1 212.4	127.1
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	28.3	290.9	37.4	352.7	121.2

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (2010=100, улирлын нөлөөллийг арилгасан туршилт тооцоо) 2014 оны 7 дугаар сард, жилийн эцсийнхээс 16.9 хувь, өмнөх сарынхаас 3.7 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 4.1 хувиар буурчээ.


Өмнөх оны мөн үеийнхээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт молибдений баяжмал, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, хайлуур жонш, газрын тос зэрэг бүтээгдэхүүний олборлолт 2.7-53.9 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт амтат ус, ундаа, шингэн сүү, бууз, банш, сүлжмэл эдлэл, цэвэр ус, гурил, гоймон, зайрмаг, вакуум цонх, хаалга, зүсмэл материал зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.6 хувиас 2.5 дахин өссөн байна.

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт нүүрс, алт, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүний олборлолт 1.7-14.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт металл цувимал, шар айраг, ган төмөр хийц, 99%-ийн катодын зэс, самнасан ноолуур, нэхий дээл, төмөр замын дэр мод зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1.5-37.7 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2014 оны эхний 7 сард 5720.1 тэрбум төг болж, 3867.6 тэрбум төг буюу 67.6 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Зураг II.12

Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өөрчлөлт, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, 2010 I-VII=100%



II.8 Дотоод худалдаа

Улсын хэмжээнд 2014 оны эхний хагас жилд нийт 52619 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 21909 буюу 41.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувь, борлуулалтын нийт орлогын 90.0 гаруй хувийг жилд 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж эзэлж байна.


Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэг аж ахуйн нэгжид ногдох орлого 2013 оны эхний хагас жилд 2415.5 сая төг байсан бол 2014 оны эхний хагас жилд 2675.5 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 260.2 сая төг буюу 10.8 хувиар нэмэгджээ.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт (оны үнээр) 2014 оны эхний хагас жилд 4363.7 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 407.4 тэрбум төг буюу 10.3 хувиар өсчээ.

Өмнөх оны мөн үеийнхээс бөөний худалдааны борлуулалт 342.6 тэрбум төг буюу 14.8 хувь, жижиглэн худалдааны 64.8 тэрбум төг буюу 3.9 хувиар өслөө.

Зураг II.13

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, тэрбум төг




Бөөний болон жижиглэн худалдааны салбарын борлуулалтын 93.0 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Худалдааны салбарын нийт борлуулалт өмнөх оны мөн үеийнхээс Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Өмнөговь, Ховд аймагт 3.7-40.4 хувиар буурч, бусад аймаг, Улаанбаатар хотод 6.3- 78.7 хувиар өсчээ.

Зураг II.14

Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, хувиар



Хүснэгт II.6

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Дэд салбар	сая төг			
	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2014 I-VI / 2013 I-VI %
Бүгд	3 584 581.2	3 956 323.8	4 363 722.2	110.3
Бөөний худалдаа	2 241 836.4	2 311 879.0	2 654 439.9	114.8
Жижиглэн худалдаа	1 342 744.8	1 644 444.8	1 709 282.3	103.9




II.9 Тээвэр

Төмөр замын тээврээр 2014 оны эхний 7 сард 11129.4 мян.т ачаа, давхардсан тоогоор 1999.8 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 807.0 мян.т буюу 6.8 хувь, зорчигчдын тоо 252.4 мян.хүн буюу 11.2 хувиар буурчээ.

Зураг II.15

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, тээсэн ачаа, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Төмөр замын тээврийн салбарын орлого 2014 оны эхний 7 сард 233.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 6.4 тэрбум төг буюу 2.7 хувиар буурчээ.

Төмөр замын нийт ачаа тээвэрлэлтэд 2014 оны эхний 7 сард дотоодын ачаа 50.1

хувь, экспортын ачаа 26.8 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс дотоодын ачаа 0.7 пункт, экспортын ачаа 2.4 пунктээр буурахад төмрийн хүдрийн тээвэрлэлт 454.2 мян.т буюу 16.7 хувь, дотоодын нүүрс тээвэрлэлт 353.8 мян.т буюу 9.6 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Импортын ачаа тээвэрлэлт нийт тээсэн ачааны 11.7 хувь, дамжин өнгөрсөн ачаа 11.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс импортын ачаа 0.2 пункт, дамжин өнгөрсөн ачаа 3.0 пунктээр нэмэгдсэн байна.


Төмөр замын тээврээр зорчигчдын тоо 2014 оны 7 дугаар сард 313.6 мян.хүн болж, өмнөх сарынхаас 12.1 мян.хүн буюу 3.7 хувиар буурчээ. Харин тээсэн ачаа 1771.2 мян.т болж, өмнөх сарынхаас 163.9 мян.т буюу 10.2 хувь, орлого 37.6 тэрбум төг болж, 31.2 сая төг буюу 0.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 76.6 мян.т буюу 4.1 хувь, зорчигчдын тоо 49.8 мян.хүн буюу 13.7 хувь, орлого 1.0 тэрбум төг буюу 2.6 хувиар буурчээ.

Агаарын тээврээр 2014 оны эхний 7 сард 1959.1 т ачаа, давхардсан тоогоор 395.2 мян. зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 374.9 т буюу 16.1 хувь, зорчигчдын тоо 44.3 мян.хүн буюу 10.1 хувиар буурчээ.

Зураг II.16

Агаарын тээврээр зорчигчдын тоо, тээсэн ачаа, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Агаарын тээврийн салбарын орлого 2014 оны эхний 7 сард 126.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.3 тэрбум төг буюу 1.0 хувиар буурав.

Агаарын тээврээр 2014 оны эхний 7 сард дотоодод зорчигчдын тоо 144.1 мян.хүн болж, өмнөх оны мөн үеийнхээс 49.3 мян.хүн буюу 25.5 хувиар буурч, олон улсад зорчигчдын тоо 251.1 мян.хүн болж, 5.0 мян.хүн буюу 2.0 хувиар өсчээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2014 оны 7 дугаар сард 325.8 мян.т болж, өмнөх сарынхаас 21.2 мян.т буюу 7.0 хувь, зорчигчдын тоо 82.5

мян.хүн болж, 18.0 мян.хүн буюу 27.8 хувиар өсч, харин орлого 23.2 тэрбум төг болж, 4.8 тэрбум төг буюу 17.2 хувиар буурчээ.

Өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 85.4 мян.т буюу 20.8 хувь, зорчигчдын тоо 19.6 мян.хүн буюу 19.2 хувь, орлого 6.4 тэрбум төг буюу 21.5 хувиар буурсан байна.



II.10 Нийтийн хоол, зочид буудал

Нийтийн хоол

Нийтийн хоолны салбарын мэдээнд 2014 оны эхний хагас жилд 733 аж ахуйн нэгж хамрагдсан нь уг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 53.6 хувь, нийт орлогын 85.0 гаруй хувийг эзэлж байна.

Эдгээр аж ахуйн нэгжийн нийт орлого 2014 оны эхний хагас жилд 73.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 12.0 тэрбум төг буюу 14.0 хувиар буурахад тусгай захиалгат хоолоор үйлчилдэг аж ахуйн нэгжийн орлого нь 28.3 тэрбум төг буюу 62.6 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

Нийтийн хоолны салбарын мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжийн нэг суудалд ногдох дундаж орлого 2014 оны эхний хагас жилд дунджаар 1.6 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 422.5 мян.төг буюу 35.0 хувиар өсчээ. Энэ өсөлтөд рестораны нэг суудалд ногдох дундаж орлого 783.9 мян.төг буюу 47.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зочид буудал

Зочид буудлын мэдээнд 2014 оны эхний хагас жилд 305 аж ахуйн нэгж хамрагдсан нь уг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 70.0 хувь, нийт орлогын 85.0 гаруй хувийг эзэлж байна. Эдгээр аж ахуйн нэгжийн орлого 2014 оны эхний хагас жилд 52.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 3.3 тэрбум төг буюу 5.9 хувиар буурахад 3, түүнээс дээш одтой буудлын орлого 6.7 тэрбум төг буюу 21.0 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Зочид буудлын нэг өрөөнд ногдох дундаж орлого 2014 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 643.1 мян. төг буюу 6.9 хувиар буурахад 3, түүнээс дээш одтой зочид буудлын нэг өрөөнд ногдох дундаж орлого 4.7 сая төг буюу 23.4 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Зочид буудлаар 2014 оны эхний хагас жилд үйлчлүүлэгчдийн 73.8 хувь нь Монгол Улсын иргэд, 26.2 хувь нь гадаадын иргэд байна. Нэг зочид буудалд дунджаар 2014 оны эхний хагас жилд 822.7 зочин ногдож, нэг зочин дунджаар 1.3 хоног байрласан байна. Нэг зочинд ногдох дундаж орлого 207.5 мян. төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 12.1 мян. төг буюу 5.5 хувиар буурсан байна.

Хүснэгт II.8

Нийтийн хоолны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Хүснэгт II.7

Үзүүлэлт	Орлого (сая төг)			Суудлын тоо			Нэг суудалд ногдох дундаж орлого* (мян. төг)		
	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI
	Ресторан	21 148.0	21 467.2	36 320.0	10 602	13 126	15 012	1 994.7	1 635.5
Кафе	4 870.3	6 448.7	6 989.1	6 434	7 514	6 608	757.0	858.2	1 057.7
Баар	2 419.5	3 167.7	4 180.6	5 673	6 124	6 164	426.5	517.3	678.2
Гуанз	5 861.5	9 406.6	9 276.6	5 697	6 550	6 874	1 028.9	1 436.1	1 349.5
Тусгай захиалгат хоолоор үйлчилдэг аж ахуйн нэгж	34 222.0	45 201.6	16 899.0	-	-	-	-	-	-
Дүн	68 521.3	85 691.8	73 665.3	28 406	33 314	34 658	1 207.5	1 215.4	1 637.9

Тайлбар: * - Нэг суудалд ногдох дундаж орлогыг салбарын дүнгээр тооцоход тусгай захиалгат хоолоор үйлчилдэг аж ахуйн нэгжийн орлогыг оруулаагүй.

Зочид буудлын салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	Орлого (сая төг)			Өрөөний тоо			Зочдын тоо		
	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI
	Зэрэглэлгүй буудал	12 167.4	22 025.2	25 354.1	3 489	3 893	3 878	138 769	172 267
2 одтой буудал	1 088.0	1 532.5	1 578.1	312	443	468	17 934	15 321	16 791
3, түүнээс дээш одтой буудал	22 259.4	31 787.0	25 121.6	1 453	1 592	1 642	88 417	64 491	50 579
Дүн	35 514.8	55 344.7	52 053.9	5 254	5 928	5 988	245 120	252 079	250 919

II.8-р хүснэгтийн үргэлжлэл

Үзүүлэлт	Зочид буудлын нэг өрөөнд ногдох дундаж орлого (мян.төг)			Нэг зочинд ногдох дундаж орлого (мян.төг)		
	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI
	Зэрэглэлгүй буудал	3 487.4	5 657.6	6 537.9	87.7	127.9
2 одтой буудал	3 487.2	3 459.5	3 372.1	60.7	100.0	94.0
3, түүнээс дээш одтой буудал	15 319.6	19 966.7	15 299.4	251.8	492.9	496.7
Дүн	6 759.6	9 336.2	8 693.0	144.9	219.6	207.5



II.11 Даатгал

Улсын хэмжээнд 2014 оны эхний хагас жилд 17 аж ахуйн нэгж, байгууллага даатгалын үйл ажиллагаа эрхэлж, даатгалын хураамжийн орлого 56.4 тэрбум төгрөгт хүрч, даатгалын нөхөн төлбөрт 15.4 тэрбум төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс даатгалын хураамжийн орлого 14.4 тэрбум төг буюу 34.4 хувь, даатгалын нөхөн төлбөр 3.7 тэрбум төг буюу 32.1 хувиар нэмэгджээ.

Даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 14.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд эд хөрөнгийн даатгалын орлого 7.4 тэрбум төг буюу 31.6 хувь, хариуцлагын даатгалын орлого 5.2 тэрбум төг буюу 40.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 3.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд хариуцлагын даатгалын нөхөн төлбөр 1.5 тэрбум төг буюу 29.8 хувь, санхүүгийн даатгалынх 1.2 тэрбум төг буюу 2.3 дахин өссөнтэй холбоотой байна.

Даатгуулагчийн тоо, даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, даатгалын төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2012 I-VI	2013 I-VI	2014 I-VI	2014 I-VI 2013 I-VI	%
Даатгуулагчийн тоо					
Амь нас, эрүүл мэндийн даатгал (арилжааны)	247 428	45 637	99 808		218.7
Эд хөрөнгийн даатгал	67 467	75 694	147 195		194.5
Хариуцлагын даатгал	268 000	226 704	385 057		169.9
Санхүүгийн даатгал	747	3 681	7 028		190.9
Бүгд	583 642	351 716	639 088		181.7
Хураамжийн орлого, сая төг					
Амь нас, эрүүл мэндийн даатгал (арилжааны)	3 101.9	3 708.1	4 774.1		128.7
Эд хөрөнгийн даатгал	23 869.2	23 398.6	30 794.7		131.6
Хариуцлагын даатгал	13 670.5	12 954.0	18 192.4		140.4
Санхүүгийн даатгал	880.6	1 871.8	2 603.4		139.1
Бүгд	41 522.3	41 932.5	56 364.6		134.4
Нөхөн төлбөр, сая төг					
Амь нас, эрүүл мэндийн даатгал (арилжааны)	853.3	974.5	1 553.8		159.4
Эд хөрөнгийн даатгал	6 379.8	4 784.4	5 256.8		109.9
Хариуцлагын даатгал	1 314.0	4 957.9	6 433.5		129.8
Санхүүгийн даатгал	618.2	943.2	2 157.9		228.8
Бүгд	9 165.3	11 660.0	15 402.0		132.1

Даатгалын байгууллагад 2014 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 639.1 мянган даатгуулагч даатгуулснаас хариуцлагын даатгалд 385.1 мянга, эд хөрөнгийн даатгалд 147.2 мянга, амь нас, эрүүл мэндийн (арилжааны) даатгалд 99.8 мянга, санхүүгийн даатгалд 7.0 мянган даатгуулагч хамрагджээ

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА



С.МЭНДСАЙХАН

2014 оны 8 дугаар сарын 12

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар
MAIN INDICATORS, as of the first 7 months of selected years

Үзүүлэлтүүд	Indicators	2013 I-VII	2014 I-VII	2014 I-VII 2013 I-VII %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд	Social statistical indicators			
Төрсөн хүүхдийн тоо	<i>Number of births</i>	46 043	47 587	103.4
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, 7 дугаар сарын эцэст	<i>Number of registered unemployed, at the end of July</i>	38 924	34 681	89.1
Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	<i>Number of infectious disease cases</i>	24 530	19 339	78.8
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	<i>Number of committed offences</i>	14 816	15 628	105.5
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд	Macro economic statistical indicators			
Дотоодын нийт бүтээгдэхүүн, эхний хагас жилийн байдлаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	<i>Gross domestic product, by first half year, at 2010 constant prices, bln.tog</i>	6 300.8	6 634.8	105.3
Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, оны эхнээс, хувиар	<i>National consumer price index, from the beginning of the year, percent</i>	4.9	7.2	-
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө*, 7 дугаар сарын эцэст, тэрбум төг	<i>Currency in circulation* at the end of July, bln.tog</i>	832.2	859.6**	103.3
Мөнгө M1*, 7 дугаар сарын эцэст, тэрбум төг	<i>Money M1*, at the end of July, bln.tog</i>	1 927.6	1 704.2**	88.4
Мөнгө M2*, 7 дугаар сарын эцэст, тэрбум төг	<i>Money M2* at the end of July, bln.tog</i>	8 088.7	10 081.0**	124.6
Валютын зах зээлийн нэрлэсэн ханш, 7 дугаар сарын дундаж, 1 ам.доллар=төгрөг*	<i>Market exchange rate, at the average of July, 1 USD=togrog*</i>	1 474.1	1 844.1	125.1
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж, тэрбум төг	<i>Total equilibrated revenue and grants of General Government budget, bln.tog</i>	3 040.0	3 305.2	108.7
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл, тэрбум төг	<i>Total expenditure and net lending of General Government budget, bln.tog</i>	3 185.7	3 466.1	108.8
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл, тэрбум төг	<i>Equilibrated overall balance of General Government budget bln.tog</i>	- 145.6	- 160.9	110.5
Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого, тэрбум төг	<i>General Government current budget revenue, bln.tog</i>	3 039.5	3 304.2	108.7
Улсын нэгдсэн төсвийн урсгал зардал, тэрбум төг	<i>General Government current budget expenditure, bln.tog</i>	2 531.3	2 921.8	115.4
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл, тэрбум төг	<i>Equilibrated current balance of General Government budget, bln.tog</i>	508.2	382.3	75.2
Экспорт, сая ам.долл	<i>Exports, mln.USD</i>	2 353.6	2 940.5	124.9
Импорт, сая ам.долл	<i>Imports, mln.USD</i>	3 685.0	3 148.1	85.4
Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долл	<i>External trade balance, mln.USD</i>	-1 331.4	- 207.6	15.6
Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд	Economic statistical indicators			
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр, тэрбум төг	<i>Gross industrial output, at current prices, bln.tog</i>	3 476.7	4 812.3	138.4
Үүнээс:	<i>Of which:</i>			
-Уул уурхай, олборлох аж үйлдвэр	<i>-Mining and quarrying</i>	2 231.7	3 247.2	145.5
-Боловсруулах аж үйлдвэр	<i>-Manufacturing</i>	954.1	1 212.4	127.1
-Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	<i>-Electricity, thermal energy and water supply</i>	290.9	352.7	121.2
Төмөр замын тээврээр тээсэн ачаа мян.т	<i>Carried freight by railway transport, thous.t</i>	11 936.4	11 129.4	93.2
Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, мян.хүн	<i>Carried passengers by railway transport, thous.persons</i>	2 252.2	1 999.8	88.8
Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн	<i>Carried freight by air transport, ton</i>	2 334.0	1 959.1	83.9
Агаарын тээврээр зорчигчдын тоо, мян.хүн	<i>Carried passengers by air transport, thous.persons</i>	439.5	395.2	89.9

* Эх үүсвэр: Монголбанкны статистикийн сарын мэдээлэл

* Source: *Monthly statistical bulletin, Bank of Mongolia*

** Тайлбар: Урьдчилсан гүйцэтгэл

** Note: *Preliminary results*

**I. ХӨДӨЛМӨР
LABOUR**

1.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО, дэд салбараар, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар
EMPLOYMENT IN INDUSTRY, by divisions, as of July, selected years

Аж үйлдвэрийн салбар	Industrial division	2013 VII	2014 VII	$\frac{2014 VII}{2013 VII}$ %
Аж үйлдвэрийн салбар	Industrial division	65 427	65 348	99.9
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	Mining and quarrying	23 319	22 479	96.4
Нүүрс олборлолт	Mining of coal and lignite, extraction of peat	7 604	6 664	87.6
Газрын тос олборлолт	Extraction of crude petroleum	1 905	1 346	70.7
Металлын хүдэр олборлолт	Mining of metal ores	11 743	12 486	106.3
Бусад ашигт малтмал олборлолт	Other mining and quarrying	2 067	1 983	95.9
Боловсруулах аж үйлдвэр	Manufacturing	29 090	29 904	102.8
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	Manufacture of food products and beverages	11 248	11 888	105.7
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	Production, processing and preserving of meat, fish, fruit, vegetables, oils, fats	1 400	1 107	79.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of dairy products	880	906	103.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	Manufacture of grain mill products, starches, starch products, and prepared animal feeds	1 279	1 262	98.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of other food products	3 728	4 806	128.9
Ундаа үйлдвэрлэл / согтууруулах ундаа ороод /	Manufacture of beverages / includes alcohol drinks/	3 961	3 807	96.1
Тамхи үйлдвэрлэл	Manufacture of tobacco products	119	112	94.1
Нэхмэлийн үйлдвэрлэл	Manufacture of textiles	4 536	5 055	111.4
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	Manufacture of wearing apparel, dressing and dyeing of fur	1 277	1 479	115.8
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	Tanning, dressing of leather, manufacture of luggage, handbags, saddlery harness, footwear	733	321	43.8
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	Manufacture of wood and wooden products	877	645	73.5
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of paper and paper products	250	292	116.8
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	Publishing, printing and reproduction of recorded media	1 105	939	85.0
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	Manufacture of coke and briquette	232	230	99.1
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of chemicals and chemical products	1 085	1 098	101.2
Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Manufacture of rubber and plastics products	285	321	112.6
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	Production of other non-metallic mineral products	4 698	4 130	87.9
Төмрийн үйлдвэрлэл	Manufacture of basic metals	1 867	1 963	105.1
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	Manufacture of fabricated metal products, except machinery	270	658	243.7
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	Manufacture of office accounting and computing	55	71	129.1
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of electrical and apparatus	17	-	-
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of medical precision and optical instruments	57	51	89.5
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	Manufacture of other transport equipment	135	94	69.6
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	Manufacture of furniture others	244	557	228.3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	Electricity, thermal energy and water supply	13 018	12 965	99.6
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	Electricity, thermal energy, steam	9 580	9 627	100.5
Ус ариутгал, усан хангамж	Collection, purification and distribution of water	3 438	3 338	97.1

1.2 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, хүйсээр, улирлаар

EMPLOYMENT STATUS OF THE POPULATION AGED 15 YEARS AND OVER, by sex and quarter

мян.хүн/thous.persons

Үзүүлэлт	Indicators	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	<i>Economically active population</i>	1 224.2	1 160.3	1 204.2
Ажиллагчид	<i>Employed</i>	1 135.3	1 051.6	1 102.8
Ажилгүй иргэд	<i>Unemployed</i>	88.9	108.7	101.4
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	<i>Economically inactive population</i>	696.5	719.3	704.5
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	<i>Labour force participation rate,%</i>	63.7	61.7	63.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	<i>Employment rate,%</i>	59.1	55.9	57.8
Ажилгүйдлийн түвшин, %	<i>Unemployment rate, %</i>	7.3	9.4	8.4
Үүнээс: Эмэгтэй	Of which: Female			
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	<i>Economically active population</i>	602.5	552.1	562.8
Ажиллагчид	<i>Employed</i>	556.6	505.6	519.4
Ажилгүй иргэд	<i>Unemployed</i>	45.9	46.5	43.4
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	<i>Economically inactive population</i>	411.1	427.3	418.7
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	<i>Labour force participation rate,%</i>	59.4	56.4	57.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	<i>Employment rate,%</i>	54.9	51.6	52.9
Ажилгүйдлийн түвшин, %	<i>Unemployment rate, %</i>	7.6	8.4	7.7

1.3 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТЭЭР, улирлаар

EMPLOYMENT OF THE POPULATION AGED 15 YEARS AND ABOVE, BY SELECTED INDICATORS, by quarter

мян.хүн/thous.persons

Үзүүлэлт	Indicators	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
Тухайн үеийн 15, түүнээс дээш насны ажиллагчдын тоо	<i>Currently employed persons aged 15 years and over</i>	1 135.3	1 051.6	1 102.8
Эрэгтэй	<i>Male</i>	578.7	546.0	583.4
Эмэгтэй	<i>Female</i>	556.6	505.6	519.4
Хот	<i>Urban</i>	643.8	619.1	643.7
Хөдөө	<i>Rural</i>	491.5	432.5	459.1
Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар:	<i>By main sectors of economic activities:</i>			
Хөдөө аж ахуй	<i>Agriculture</i>	327.9	291.6	321.7
Үйлдвэрлэл	<i>Production</i>	228.2	211.7	223.7
Үйлчилгээ	<i>Services</i>	579.2	548.3	557.4
Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар:	<i>By employment status:</i>			
Цалин хөлстэй ажиллагч	<i>Paid employee</i>	539.7	517.6	541.3
Ажил олгогч	<i>Employer</i>	14.0	13.8	18.2
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	<i>Self-employed</i>	251.8	229.6	218.0
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин, хөлсгүй оролцогч	<i>Unpaid family workers</i>	36.9	19.3	22.2
Мал аж ахуй эрхлэгч*	<i>Employed in animal husbandry*</i>	289.7	269.1	301.6
Бусад	<i>Other</i>	3.2	2.2	1.5

* Мал аж ахуй эрхлэгч гэж жилийн дөрвөн улирлын туршидөөрийн мал аж ахуйг эрхэлж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэнийг ойлгоно.

* *Employed in animal husbandry are citizens who are employed in animal husbandry all around the year, and get their means of subsistence from income derived from animal or livestock products and raw materials it provides.*

1.4 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр,
улирлаар
ECONOMICALLY ACTIVE POPULATION AGED 15 YEARS AND OVER, by regions, aimags
and the capital, by quarter

		мян.хүн/thous.persons		
Аймаг, нийслэл	Aimags and the capital	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
БҮГД	TOTAL	1 224.2	1 160.3	1 204.2
	Баруун бүс	Western region		
Дүн	Subtotal	182.4	172.9	183.5
Баян-Өлгий	Bayan-Olgii	43.1	43.5	45.8
Говь-Алтай	Govi-Altai	26.1	26.4	25.5
Завхан	Zavkhan	40.6	37.1	40.1
Увс	Uvs	35.0	33.4	35.9
Ховд	Khovd	37.6	32.5	36.2
	Хангайн бүс	Khangai region		
Дүн	Subtotal	286.1	252.6	260.1
Архангай	Arkhangai	46.6	43.4	45.5
Баянхонгор	Bayankhongor	39.6	37.0	41.0
Булган	Bulgan	29.7	28.5	26.4
Орхон	Orkhon	39.3	38.4	42.8
Өвөрхангай	Ovorkhangai	66.6	53.3	55.9
Хөвсгөл	Khovsgol	64.3	52.0	48.5
	Төвийн бүс	Central region		
Дүн	Subtotal	212.0	188.2	206.8
Говьсүмбэр	Govisumber	6.2	5.4	5.6
Дархан-Уул	Darkhan-Uul	33.7	31.1	33.1
Дорноговь	Dornogovi	29.8	27.1	31.0
Дундговь	Dundgovi	22.7	21.1	22.7
Өмнөговь	Omnogovi	25.6	29.7	31.2
Сэлэнгэ	Selenge	45.6	31.1	39.1
Төв	Tov	48.4	42.7	44.1
	Зүүн бүс	Eastern region		
Дүн	Subtotal	92.0	93.9	91.0
Дорнод	Dornod	30.5	32.9	30.5
Сүхбаатар	Sukhbaatar	24.5	26.0	27.9
Хэнтий	Khentii	37.0	35.0	32.6
	Улаанбаатар	Ulaanbaatar		
Улаанбаатар	Ulaanbaatar	451.7	452.7	462.8

1.5. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, шалтгаанаар, улирлаар
ECONOMICALLY INACTIVE POPULATION AGED 15 YEARS AND OVER, by reasons and quarter

		мян.хүн/thous.persons		
Шалтгаан	Reason	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
БҮГД	TOTAL	696.5	719.3	704.5
Гэрийн ажилтай	Household duties	55.5	53.6	56.6
Суралцдаг	Studied	241.2	240.4	236.8
Сурахаар явах гэж байгаа	Will go to study	4.1	2.1	6.9
Тэтгэвэрт, өндөр настан	Retired, elderly	188.5	212.4	209.3
Хөгжлийн бэрхшээлтэй	Disabled	58.1	61.8	54.8
Ажил хийхийг хүсээгүй	Not interested in working	11.5	10.8	13.4
Хүүхэд асарсан	Took care of children	67.8	69.3	78.9
Өвчтэй байсан	Sick	14.0	22.4	15.4
Өвчтөн, өндөр настан асарсан	Caring patients or elderly	7.6	10.4	6.2
Бусад	Other	48.2	36.1	26.2

1.6. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
EMPLOYED AGED 15 YEARS AND OVER, by regions, aimags and the capital, by quarter

мян.хүн/thous.persons

Аймаг, нийслэл	Aimags and the capital	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
БҮГД	TOTAL	1 135.3	1 051.6	1 102.8
	Баруун бүс	Western region		
Дүн	Subtotal	164.0	147.1	165.5
Баян-Өлгий	Bayan-Olgii	35.6	30.4	38.6
Говь-Алтай	Govi-Altai	22.3	22.2	24.2
Завхан	Zavkhan	38.5	35.0	38.8
Увс	Uvs	31.7	30.8	32.6
Ховд	Khovd	35.9	28.7	31.3
	Хангайн бүс	Khangai region		
Дүн	Subtotal	259.0	230.8	239.3
Архангай	Arkhangai	44.6	41.5	42.6
Баянхонгор	Bayankhongor	36.0	33.3	40.6
Булган	Bulgan	27.6	25.2	21.5
Орхон	Orkhon	32.7	33.3	35.0
Өвөрхангай	Ovorkhangai	64.8	50.8	54.4
Хөвсгөл	Khovsgol	53.3	46.7	45.2
	Төвийн бүс	Central region		
Дүн	Subtotal	199.5	169.2	183.1
Говьсүмбэр	Govisumber	5.7	5.1	5.2
Дархан-Уул	Darkhan-Uul	30.8	26.8	28.1
Дорноговь	Dornogovi	27.3	23.2	26.2
Дундговь	Dundgovi	21.8	20.0	21.4
Өмнөговь	Omnogovi	24.6	26.4	28.8
Сэлэнгэ	Selenge	44.4	27.7	33.0
Төв	Tov	44.9	40.0	40.4
	Зүүн бүс	Eastern region		
Дүн	Subtotal	80.4	77.9	80.4
Дорнод	Dornod	27.6	27.1	27.4
Сүхбаатар	Sukhbaatar	23.2	21.2	27.0
Хэнтий	Khentii	29.6	29.6	26.0
	Улаанбаатар	Ulaanbaatar		
Улаанбаатар	Ulaanbaatar	432.4	426.6	434.5

1.7. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, улирлаар

EMPLOYED AGED 15 YEARS AND OVER, by classification of economic activities and quarter

мян.хүн/thous.persons

Салбар	Divisions	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
БҮГД	TOTAL	1 135.3	1 051.6	1 102.8
Үүнээс:	Of which:			
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Agriculture, forestry, fishing & hunting	327.9	291.6	321.7
Уул уурхай, олборлолт	Mining & quarrying	45.1	41.3	40.3
Боловсруулах үйлдвэрлэл	Manufacturing	94.4	83.6	79.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Electricity, gas, steam and air conditioning supply	13.3	13.8	18.2
Усан хангамж; бохир үс зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	Water supply; sewerage, waste management and remediation activities	5.5	6.3	7.3
Барилга	Construction	69.9	66.7	78.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Wholesale & retail trade, repair of motor vehicles and motorcycles	168.5	164.9	173.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Transportation and storage	61.1	70.9	63.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Accommodation and food service activities	33.9	32.9	31.4
Мэдээлэл, холбоо	Information & Communication	17.6	21.2	13.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Financial and insurance activities	22.3	23.4	19.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Real estate activities	0.5	0.8	0.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Professional, scientific and technical activities	13.1	10.1	15.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Administrative and support service activities	19.1	9.8	12.9
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Public administration and defence; compulsory social insurancy	65.2	64.4	65.8
Боловсрол	Education	90.5	85.6	92.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Human health and social work activities	45.2	36.0	37.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	Arts, entertainment and recreation	9.3	9.6	10.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Other service activities	27.2	16.5	19.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	Activities of households as employers	3.4	0.6	1.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	Activities of extraterritorial organizations and bodies	2.3	1.6	2.1

1.8. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
 UNEMPLOYED AGED 15 YEARS AND OVER, by regions, aimags and the capital, by quarter

		мян.хүн/thous.persons		
Аймаг, нийслэл	<i>Aimags and the capital</i>	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
БҮГД	TOTAL	88.9	108.7	101.4
	Баруун бүс	Western region		
Дүн	Subtotal	18.4	25.8	18.0
Баян-Өлгий	<i>Bayan-Olgii</i>	7.5	13.1	7.2
Говь-Алтай	<i>Govi-Altai</i>	3.8	4.2	1.3
Завхан	<i>Zavkhan</i>	2.1	2.1	1.3
Увс	<i>Uvs</i>	3.3	2.6	3.3
Ховд	<i>Khovd</i>	1.7	3.8	4.9
	Хангайн бүс	Khangai region		
Дүн	Subtotal	27.1	21.8	20.8
Архангай	<i>Arkhangai</i>	2.0	1.9	2.9
Баянхонгор	<i>Bayankhongor</i>	3.6	3.7	0.4
Булган	<i>Bulgan</i>	2.1	3.3	4.9
Орхон	<i>Orkhon</i>	6.6	5.1	7.8
Өвөрхангай	<i>Ovorkhangai</i>	1.8	2.5	1.5
Хөвсгөл	<i>Khovsgol</i>	11.0	5.3	3.3
	Төвийн бүс	Central region		
Дүн	Subtotal	12.5	19.0	23.7
Говьсүмбэр	<i>Govisumber</i>	0.5	0.3	0.4
Дархан-Уул	<i>Darkhan-Uul</i>	2.9	4.3	5.0
Дорноговь	<i>Dornogovi</i>	2.5	3.9	4.8
Дундговь	<i>Dundgovi</i>	0.9	1.1	1.3
Өмнөговь	<i>Omnogovi</i>	1.0	3.3	2.4
Сэлэнгэ	<i>Selenge</i>	1.2	3.4	6.1
Төв	<i>Tov</i>	3.5	2.7	3.7
	Зүүн бүс	Eastern region		
Дүн	Subtotal	11.6	16.0	10.6
Дорнод	<i>Dornod</i>	2.9	5.8	3.1
Сүхбаатар	<i>Sukhbaatar</i>	1.3	4.8	0.9
Хэнтий	<i>Khentii</i>	7.4	5.4	6.6
	Улаанбаатар	Ulaanbaatar		
Улаанбаатар	Ulaanbaatar	19.3	26.1	28.3

1.9. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
LABOUR FORCE PARTICIPATION RATE, by regions, aimags and the capital, by quarter

		хувь/percentage		
Аймаг, нийслэл	<i>Aimags and the capital</i>	2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
БҮГД	TOTAL	63.7	61.7	63.1
	Баруун бүс	Western region		
Дүн	Subtotal	72.2	73.0	75.8
Баян-Өлгий	<i>Bayan-Olgii</i>	69.6	70.6	69.5
Говь-Алтай	<i>Govi-Altai</i>	72.6	73.0	72.5
Завхан	<i>Zavkhan</i>	72.4	83.0	81.9
Увс	<i>Uvs</i>	75.4	77.0	83.4
Ховд	<i>Khovd</i>	71.7	63.6	73.8
	Хангайн бүс	Khangai region		
Дүн	Subtotal	75.0	69.5	69.3
Архангай	<i>Arkhangai</i>	73.0	76.7	76.0
Баянхонгор	<i>Bayankhongor</i>	65.5	65.7	70.2
Булган	<i>Bulgan</i>	77.1	74.8	66.9
Орхон	<i>Orkhon</i>	69.5	62.3	66.0
Өвөрхангай	<i>Ovorkhangai</i>	82.7	73.1	75.7
Хөвсгөл	<i>Khovsgol</i>	79.2	66.7	61.7
	Төвийн бүс	Central region		
Дүн	Subtotal	67.2	62.5	64.3
Говьсүмбэр	<i>Govisumber</i>	61.6	47.9	58.8
Дархан-Уул	<i>Darkhan-Uul</i>	55.8	48.4	47.7
Дорноговь	<i>Dornogovi</i>	77.1	65.1	72.1
Дундговь	<i>Dundgovi</i>	75.7	75.9	73.3
Өмнөговь	<i>Omnogovi</i>	57.2	70.5	73.2
Сэлэнгэ	<i>Selenge</i>	66.1	55.0	56.9
Төв	<i>Tov</i>	77.6	74.4	76.8
	Зүүн бүс	Eastern region		
Дүн	Subtotal	63.2	64.9	66.1
Дорнод	<i>Dornod</i>	49.2	57.0	54.3
Сүхбаатар	<i>Sukhbaatar</i>	68.7	70.0	80.2
Хэнтий	<i>Khentii</i>	77.2	70.3	69.7
	Улаанбаатар	Ulaanbaatar		
Улаанбаатар	Ulaanbaatar	54.7	54.3	55.6

1.10. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар

UNEMPLOYMENT RATE, by regions, aimags and the capital, by quarter

Аймаг, нийслэл	Aimags and the capital	хувь/percentage		
		2013 IV-VI	2014 I-III	2014 IV-VI
БҮГД	TOTAL	7.3	9.4	8.4
	Баруун бүс	Western region		
Дүн	Subtotal	10.1	14.9	9.8
Баян-Өлгий	Bayan-Olgii	17.4	30.1	15.7
Говь-Алтай	Govi-Altai	14.6	16.0	5.1
Завхан	Zavkhan	5.2	5.6	3.2
Увс	Uvs	9.3	7.9	9.1
Ховд	Khovd	4.6	11.7	13.5
	Хангайн бүс	Khangai region		
Дүн	Subtotal	9.5	8.6	8.0
Архангай	Arkhangai	4.2	4.4	6.4
Баянхонгор	Bayankhongor	9.1	10.1	1.1
Булган	Bulgan	7.2	11.5	18.6
Орхон	Orkhon	16.8	13.3	18.2
Өвөрхангай	Ovorkhangai	2.7	4.6	2.8
Хөвсгөл	Khovsgol	17.1	10.1	6.9
	Төвийн бүс	Central region		
Дүн	Subtotal	5.9	10.1	11.4
Говьсүмбэр	Govisumber	8.4	6.0	6.8
Дархан-Уул	Darkhan-Uul	8.7	13.8	15.1
Дорноговь	Dornogovi	8.2	14.2	15.5
Дундговь	Dundgovi	4.1	5.3	5.6
Өмнөговь	Omnogovi	3.7	11.2	7.6
Сэлэнгэ	Selenge	2.6	11.0	15.6
Төв	Tov	7.3	6.3	8.4
	Зүүн бүс	Eastern region		
Дүн	Subtotal	12.6	17.0	11.6
Дорнод	Dornod	9.5	17.5	10.0
Сүхбаатар	Sukhbaatar	5.5	18.4	3.3
Хэнтий	Khentii	19.9	15.4	20.3
	Улаанбаатар	Ulaanbaatar		
Улаанбаатар	Ulaanbaatar	4.3	5.8	6.1

1.11 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО*, бүс, аймаг, нийслэлээр, сарын эцэст
*NUMBER OF REGISTERED UNEMPLOYED**, by regions, aimags and the capital, at the end
of months

Бүс, аймаг, нийслэл <i>Regions, aimags and the capital</i>	2013		2014		2014 VII. % 2013 VII
	VI	VII	VI	VII	
Дүн / Total	41 747	38 924	33 882	34 681	89.1
Баруун бүс / Western region	6 340	5 512	4 925	4 930	89.4
БӨ / BO	1 306	1 125	1 282	1 326	117.9
ГО / GO	743	935	968	971	103.9
ЗА / ZA	1 343	930	630	651	70.0
УВ / UV	1 069	857	907	835	97.4
ХО / KHO	1 879	1 665	1 138	1 147	68.9
Хангайн бүс / Khangai region	11 113	10 107	4 673	4 899	48.5
АР / AR	1 569	1 562	702	884	56.6
БХ / BKH	1 420	1 433	665	650	45.4
БУ / BU	499	723	323	296	40.9
ОР / OR	2 224	1 958	991	1 002	51.2
ӨВ / OV	3 463	2 588	731	788	30.4
ХӨ / KHS	1 938	1 843	1 261	1 279	69.4
Төвийн бүс / Central region	6 944	6 356	6 104	6 209	97.7
ГС / GS	158	125	248	194	155.2
ДА / DA	2 281	2 240	1 965	2 036	90.9
ДО / DO	988	999	1 329	1 481	148.2
ДУ / DU	787	550	295	281	51.1
ӨМ / OM	917	723	666	612	84.6
СЭ / SE	1 137	1 153	1 096	1 121	97.2
ТӨ / TO	676	566	505	484	85.5
Зүүн бүс / Eastern region	4 862	5 459	3 549	3 511	64.3
ДД / DD	2 854	3 490	1 742	1 752	50.2
СҮ / SU	901	909	703	714	78.5
ХЭ / KHE	1 107	1 060	1 104	1 045	98.6
Улаанбаатар / Ulaanbaatar	12 488	11 490	14 631	15 132	131.7

Эх үүсвэр: * Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

Source: * Monthly report of the Ministry of Labour

1.12 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО*, насны бүлэг, бүс, аймаг, нийслэлээр 2014 оны 7 дугаар сарын эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED*, by age group, regions, aimags and the capital at the end of July, 2014

Бүс, аймаг, нийслэл Regions, aimags and the capital	Бүгд		Үүнээс: Насны бүлгээр Of which: By age group											
			Total	Эмэгтэй Female	15-24	Эмэгтэй Female	25-34	Эмэгтэй Female	35-44	Эмэгтэй Female	45-54	Эмэгтэй Female	55-59	Эмэгтэй Female
	34 681	19 002	11 524	6 654	12 436	6 933	6 001	3 197	3 663	1 826	749	287	308	105
Дүн / Total	4 930	2 696	1 617	949	1 740	971	921	486	526	249	80	27	46	14
Баруун бүс / Western region	1 326	706	334	190	528	300	285	135	155	76	19	5	5	-
БӨ / BO	971	563	288	165	322	204	187	111	140	71	27	10	7	2
ГО / GO	651	363	198	119	223	118	137	81	78	38	10	5	5	2
ЗА / ZA	835	465	292	180	326	179	135	75	76	31	4	-	2	-
УВ / UV	1 147	599	505	295	341	170	177	84	77	33	20	7	27	10
ХО / KHO	4 899	2 698	1 707	972	1 700	947	872	487	522	262	67	23	31	7
Хангайн бүс / Khangai region	884	454	221	123	319	162	203	100	115	60	15	5	11	4
АР / AR	650	383	228	139	240	134	119	73	59	35	4	2	-	-
БХ / BKH	296	145	119	54	87	42	42	26	40	21	7	2	1	-
БУ / BU	1 002	594	369	216	397	248	148	87	78	42	9	1	1	-
ОР / OR	788	422	250	146	274	149	169	91	90	35	4	1	1	-
ӨВ / OV	1 279	700	520	294	383	212	191	110	140	69	28	12	17	3
ХӨ / KHS	6 209	3 397	1 755	978	2 506	1 422	1 155	615	619	321	125	46	49	15
Төвийн бүс / Central region	194	95	61	30	77	44	34	11	13	6	6	3	3	1
ГС / GS	2 036	1 086	560	304	826	452	379	195	213	112	47	20	11	3
ДА / DA	1 481	876	295	174	694	427	298	184	145	75	31	12	18	4
ДО / DO	281	132	113	60	87	35	41	18	28	14	8	2	4	3
ДУ / DU	612	350	309	174	201	124	63	35	32	15	6	1	1	1
ӨМ / OM	1 121	590	251	142	454	249	256	129	132	64	21	5	7	1
СЭ / SE	484	268	166	94	167	91	84	43	56	35	6	3	5	2
ТӨ / TO	3 511	1 837	852	445	1 304	708	783	403	449	228	92	39	31	14
Зүүн бүс / Eastern region	1 752	897	453	229	673	353	349	172	206	109	52	25	19	9
ДД / DD	714	354	117	62	259	123	194	102	118	56	20	9	6	2
СҮ / SU	1 045	586	282	154	372	232	240	129	125	63	20	5	6	3
ХЭ / KHE	15 132	8 374	5 593	3 310	5 186	2 885	2 270	1 206	1 547	766	385	152	151	55
Улаанбаатар / Ulaanbaatar														

Эх үүсвэр: * Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

Source: * Monthly report of the Ministry of Labour

1.13 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО*, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар
NUMBER OF NEWLY REGISTERED UNEMPLOYED* by regions, aimags and the capital, as a first 7 months of selected years

Бүс, аймаг, нийслэл Regions, aimags and the capital	2013			2014			2014 I-VII % 2013 I-VII
	VI	VII	I-VII	VI	VII	I-VII	
Дүн / Total	13 059	5 614	59 516	9 967	11 857	55 429	93.1
Баруун бүс / Western region	1 599	759	8 859	1 460	2 147	8 152	92.0
БӨ / BO	391	130	2 105	348	896	2 552	121.2
ГО / GO	58	337	1 284	263	355	1 261	98.2
ЗА / ZA	263	74	1 590	111	265	790	49.7
УВ / UV	248	69	1 452	205	365	1 334	91.9
ХО / KHO	639	149	2 428	533	266	2 215	91.2
Хангайн бүс / Khangai region	4 642	1 014	15 714	2 051	2 126	9 735	62.0
АР / AR	1 276	149	2 507	169	683	1 411	56.3
БХ / BKH	378	266	2 251	287	248	1 021	45.4
БУ / BU	252	262	1 171	177	60	720	61.5
ОР / OR	991	91	3 718	341	349	1 355	36.4
ӨВ / OV	1 249	139	3 893	481	371	2 329	59.8
ХӨ / KHS	496	107	2 174	596	415	2 899	133.3
Төвийн бүс / Central region	1 826	1 037	8 865	1 707	1 652	8 575	96.7
ГС / GS	91	27	254	13	93	481	189.4
ДА / DA	444	278	1 872	424	491	2 087	111.5
ДО / DO	140	185	1 024	147	407	1 239	121.0
ДУ / DU	388	85	804	125	116	882	109.7
ӨМ / OM	438	110	1 584	160	185	1 223	77.2
СЭ / SE	216	274	2 098	619	168	1 435	68.4
ТӨ / TO	109	78	1 229	219	192	1 228	99.9
Зүүн бүс / Eastern region	1 447	1 122	5 821	849	1 217	5 137	88.2
ДД / DD	801	780	3 047	501	466	2 134	70.0
СҮ / SU	379	168	1 762	255	159	878	49.8
ХЭ / KHE	267	174	1 012	93	592	2 125	210.0
Улаанбаатар / Ulaanbaatar	3 545	1 682	20 257	3 900	4 715	23 830	117.6

Эх үүсвэр: * Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

Source: * Monthly report of the Ministry of Labour

1.14 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО*, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

NUMBER OF PERSONS ACQUIRED A JOB OUT OF REGISTERED UNEMPLOYED*, by regions, aimags and the capital, as a first 7 months of selected years

Бүс, аймаг, нийслэл Regions, aimags and the capital	2013			2014			2014 I-VII 2013 I-VII %
	VI	VII	I-VII	VI	VII	I-VII	
Дүн / Total	10 534	3 439	32 031	3 817	924	15 631	48.8
Баруун бүс / Western region	1 402	236	4 682	590	136	1 978	42.2
БӨ / BO	380	36	937	198	75	698	74.5
ГО / GO	79	3	451	82	1	277	61.4
ЗА / ZA	359	71	1 150	42	4	222	19.3
УВ / UV	82	33	590	27	39	252	42.7
ХО / KHO	502	93	1 554	241	17	529	34.0
Хангайн бүс / Khangai region	2 716	601	7 294	973	140	2 734	37.5
АР / AR	322	95	1 325	68	21	306	23.1
БХ / BKH	340	185	1 153	70	10	196	17.0
БУ / BU	183	38	547	71	3	210	38.4
ОР / OR	907	144	1 855	115	19	255	13.7
ӨВ / OV	454	107	1 214	266	58	774	63.8
ХӨ / KHS	510	32	1 200	383	29	993	82.8
Төвийн бүс / Central region	1 527	765	4 861	907	184	2 671	54.9
ГС / GS	45	14	152	10	24	75	49.3
ДА / DA	253	189	1 253	142	18	885	70.6
ДО / DO	186	174	782	51	17	312	39.9
ДУ / DU	223	90	399	68	9	256	64.2
ӨМ / OM	384	21	687	62	9	126	18.3
СЭ / SE	363	258	1 167	467	28	673	57.7
ТӨ / TO	73	19	421	107	79	344	81.7
Зүүн бүс / Eastern region	1 417	334	2 803	373	132	2 395	85.4
ДД / DD	795	144	1 149	161	18	823	71.6
СҮ / SU	341	160	886	195	67	562	63.4
ХЭ / KHE	281	30	768	17	47	1 010	131.5
Улаанбаатар / Ulaanbaatar	3 472	1 503	12 391	974	332	5 853	47.2

Эх үүсвэр * Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр

Source: * Monthly report of the Ministry of Labour

II. ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА
HOUSEHOLD INCOME AND EXPENDITURE

2.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, эх үүсвэр, байршлаар, 2014 оны 2 дугаар улирлын байдлаар
MONTHLY AVERAGE INCOME PER HOUSEHOLD, by sources and location, as a 2nd quarter of 2014

Орлогын төрөл	Types of income	төг tog				
		Улсын дундаж National average	Нийслэл Capital city	Аймгийн төв Aimag center	Сумын төв Soum center	Хөдөө Rural area
Орлого - Бүгд	Income - Total	1 013 956	1 196 998	982 993	851 568	801 803
1. Мөнгөн орлого - Бүгд	Monetary income - Total	924 138	1 161 993	940 957	705 675	588 375
Цалин хөлс	Wages and salaries	490 084	731 953	499 026	327 909	97 581
Тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор	Pensions, allowances and compensation	141 912	156 447	145 915	136 470	109 858
Мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	Income from livestock products	83 769	2 343	13 586	111 707	322 518
Газар тариалангийн үйлдвэрлэлийн орлого	Income from crop products	1 408	211	1 301	5 464	131
Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Income from non-agricultural production and services	117 439	173 063	136 611	65 329	21 892
Бусад орлого	Other income	89 526	97 976	144 518	58 796	36 395
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	Food and nonfood products received from others free of charge	36 664	29 846	29 589	51 971	44 942
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	Food consumption from own business	53 154	5 159	12 447	93 922	168 486

2.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, эх үүсвэр, байршлаар, 2014 оны 2 дугаар улирлын байдлаар
COMPOSITION OF MONTHLY AVERAGE INCOME PER HOUSEHOLD, by sources and location, as a 2nd quarter of 2014

Орлогын төрөл	Types of income	хувь percentage				
		Улсын дундаж National average	Нийслэл Capital city	Аймгийн төв Aimag center	Сумын төв Soum center	Хөдөө Rural area
Орлого - Бүгд	Income - Total	100.0	100.0	100.0	100.0	100.0
1. Мөнгөн орлого - Бүгд	Monetary income - Total	91.2	97.1	95.7	82.9	73.4
